



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 05 өдөр

Дугаар 166

Амардалай

Бог малын мялзан өвчнөөс урьдчилсан
сэргийлэх дархлаажуулалтыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг Зохиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлага тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3,9.4,9.5,9.6 дахь заалтууд Мал эмнэлгийн Ерөнхий газрын 2022 оны 08 дугаар сарын 16 ний өдрийн А/182 тоот "Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх, нэгдсэн дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай" тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Бог малын мялзан өвчнөөс урьдчилсан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг эрсдэл бүхий бүс нутгийн мэдрэмтгий мал сүргийг батлагдсан төлөвлөгөө хуваарийн дагуу 2022 оны 08 дугаар сарын 25-ний өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга Д.Наранцэцэг (МЭТ-ийн дарга)

Гишүүд:

М.Даваацэрэн (Дэлгэрбаяндалай МЭҮН-ийн эмч)

М.Ганьхүү (Арвин тэгш баялаг МЭҮН-ийн эмч)

Э.Дэлгэрмаа (Дэлгэрбаяндалай МЭҮН-ийн эмч)

Б.Довуучий (1-р багийн Засаг дарга)

Г.Сосорбурам (2-р багийн Засаг дарга)

Б.Баатарсүрэн (3-р багийн Засаг дарга)

Б.Баттогтох (ХААТ-ийн мэргэжилтэн)

3. Бог малын мялзан өвчнөөс урьдчилсан сэргийлэх дархлаажуулалтын товыг малчдад зарлан мэдээлэхийг ажлыг хэсгийн гишүүн Б.Довуучий, Г.Сосорбурам, Б.Баатарсүрэн нарт, хуваарийн дагуу Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн гэрээт багуудад дархлаажуулалтыг технологит хугацаанд шуурхай зохион байгуулж ажиллахыг малын эмч М.Даваацэрэн, Э.Дэлгэрмаа, М.Ганьхүү нарт тус тус үүрэг болгосугай.

4. Дархлаажуулалтын явцад хяналт тавьж, мэргэжилт арга зүй заавар зөвлөмж өгөх, вакцинжуулалтын ажлын үр дүнг 2022 оны 10 дугаар сарын 01-ний дотор багтаан орон нутгийн удирдлага болон мэргэжлийн байгууллагад танилцуулахыг Мал Эмнэлгийн Тасгийн дарга Д.Наранцэцэгт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

М.БАЯРСҮХ



2022